

*Жан-Франсуа Лиотар***ПОСТМОДЕРН ТӨЛӨВ: МЭДЛЭГИЙН ТУХАЙ ИЛТГЭЛ зохиолын хэсгээсⁱ****1.Талбар: Компьютержсэн нийгэм дэх мэдлэг**

Ажлын маань таамаглал мэдлэгийн байр байдал нийгэм нь аж үйлдвэржсэний дараах, соёл нь постмодерн эриндⁱⁱ шилжин орохын хэрээр өөрчлөгдөж байгаа гэдэгт оршино. Энэ шилжилт наанадаж, Европт сэргээн босголтын төгсгөл мэдэгдсэн 1950-аад оны сүүлээс эхлэн хэрэгжсэн. Үүний хурдан, удаан нь улсаасаа, улсын дотоодод бол идэвхт үйл ажиллагааны салбараас хамааран өөр өөр байгаа. Уг нийтлэг нөхцөл нь ерөнхий тойм хийхэд бэрхшээл учруулж буй түр зуурын тусгаарлалт юмⁱⁱⁱ. Иймд тодорхойлох хэсэг маань таамагт шинжтэй байхаас аргагүй. Ямартай ч футурологид^{iv} хэт их итгэх нь бодлогогүй хэрэг гэдгийг бүгд мэднэ.

Хэзээ ч бүрэн эвлэхгүй дүр зургийг гаргах гэж оролдохын оронд судлах зүйлийг маань шууд тодорхойлох, нэг л онцлогийг эхлэх цэгээ болгоё. Шинжлэх ухааны мэдлэг бол дискурсын нэг төрөл мөн. Тэгэхээр сүүлийн дөчин жилийн турш тэргүүний шинжлэх ухаан, технологиуд нь хэлтэй, тодруулбал авиа судлал ба хэл шинжлэлийн онол^v, харилцаа холбоо ба кибернетикийн асуудал^{vi}, алгебр ба мэдээлэлзүйн орчин үеийн онол^{vii}, компьютер ба түүний хэл^{viii}, компьютерын хэлийг өөр хооронд нь хөрвүүлэх, нийцүүлэх судалгаа^{ix}, мэдээллийг хадгалах болон мэдээний сангийн асуудал^x, телематик ба ухаалаг терминалын боловсруулалт^{xi}, парадокс судлалтай^{xii} ажиллаж байсан гэхэд болно. Энэ бол хангалттай нотолгоо (бөгөөд энэ жагсаалт дуусашгүй).

Технологийн эдгээр өөрчлөлт мэдлэгт зохих нөлөө үзүүлсэн байх учиртай. Судалгаа, олж авсан мэдлэгээ дамжуулах хэмээх мэдлэгийн үндсэн хоёр функци нь энэ нөлөөг хэдийнээ амссан, ирээдүйд ч амсана. Эхний функцийн тухайд юу ч мэдэхгүй хүнд ойлгогдохоор жишээг кибернетикээс онолын парадигмаа авсан генетик судлал өгдөг. Өөр олон жишээг дурдаж болно. Хоёрдахь функцийн талаар цахим машиныг авсаархан болгож, худалдах нь мэдээллийг олж авах, ангилах, хэрэглэх, ашиглах арга замыг өөрчилж^{xiii} байгаагаас мэдэж болно. Мэдээлэл боловсруулах машин олширох нь хүний шилжилт хөдөлгөөн (тээврийн систем), дараа нь дуу, дүрсний дамжуулалт (медиа^{xiv})-д олсон ололттой дүйцэхүйц тийм их нөлөөг мэдлэгийн эргэлтэнд үзүүлж байгаа, үзүүлэх ч болно хэмээн таамаглаж болохоор байна.

Нийтлэг ийм өөрчлөлтийн дунд мэдлэгийн мөн чанар өөрчлөгдөхгүй үлдэж чадахгүй. Мэдлэгийг мэдээллийн нэгжид^{xv} хөрвүүлсэн нөхцөлд л шинэ сувгаар нэвтэрч, үйлдэлт шинжтэй болно. Бүрдсэн мэдлэгийн тогтолцоонд ийм байдлаар хөрвүүлэх боломжгүй бүхэн хаягдана гэж, судалгааны шинэ чиглэл эцсийн үр дүн нь компьютерын хэлэнд хөрвөдөг байх бололцоогоор хязгаарлагдана гэж таамаглах хэрэгтэй. Мэдлэгийг «үйлдвэрлэгч», хэрэглэгчид ямар нэг зүйлийг нээж олох эсвэл сурах гэхдээ эдгээр хэл рүү хөрвүүлэх хэрэгслийг эзэмших хэрэгтэй, эзэмших ч ёстой болно. Хөрвүүлэгч машины талаарх судалгаа урагш нилээд ахисан^{xvi}. Компьютерын манлайллын хамт тодорхой зүй тогтол, тухайлаад «мэдлэг» болж тооцогдох хэллэгт тавих тодорхой цогц шаардлага дэвшигдэж байна.

Иймд «танин мэдэгчийн» тухайд мэдлэг бүрэн гадагшилж, аль ч шатанд тэрээр танин мэдэх үйл явцад оролцож чадна хэмээн найдаж болно. Мэдлэгийг олж авах нь оюун ухааныг сургахтай (*Bildung*) тэр бүү хэл тухайн хүнтэй салшгүй холбоотой гэдэг өмнөх зарчим хуучирч, хэрэгцээнээс гарна. Мэдлэг нийлүүлэгч, хэрэглэгч хоёрын нийлүүлж, хэрэглэж буй мэдлэгтээ хандах харилцаа нь барааг үйлдвэрлэгч, хэрэглэгч хоёр үйлдвэрлэж, хэрэглэж буй бараандаа хандах харилцаанд илэрдэг хэлбэртэй буюу үнэлэмжийн хэлбэртэй (*forme valeur*) болж байна, болох ч болно. Мэдлэг зарагдахаар бүтээгдэж байгаа, бүтээгдэх ч болно, шинэ бүтээгдэхүүнд үнэлэмж нэмэхээр хэрэглэгдэж байгаа, хэрэглэгдэх ч болно. Аль ч тохиолдолд зорилго нь арилжигдах явдал юм. Мэдлэг өөрөө зорилго байхаа больж, «хэрэглээний үнэлэмжээ» алдаж байна^{xvii}.

Сүүлийн хэдэн арван жилийн дотор мэдлэг нь үйлдвэрлэх гол хүч болж^{xviii}, өндөр хөгжсөн орнуудын ажиллах хүчний бүрэлдэхүүнийг мэдэгдэхүйц өөрчилж^{xix}, хөгжиж буй орнуудад үндсэн тээг болж буйг нийтээр хүлээн зөвшөөрлөө. Аж үйлдвэржсэний дараах буюу постмодерн эрин үед шинжлэх ухаан нь төрт улсын үйлдвэрлэх хүчин чадлын нөөц дэх давуу байдлаа хадгалан, лавшруулах нь эргэлзээгүй. Үнэндээ энэ нөхцөл байдал нь хөгжиж байгаа болон хөгжсөн орны ялгаа ирээдүйд улам л нэмэгдэнэ гэсэн дүгнэлт хийх нэг үндэслэл болно^{xx}.

Гэхдээ асуудлын энэ тал үүнд нэмэлт болдог нөгөө талыг далдлах учиргүй. Үйлдвэрлэх хүчийг нэмэгдүүлэхэд зайлшгүй мэдээллэн барааны хэлбэрээрээ мэдлэг нь эрх мэдлийн төлөөх дэлхий нийтийн тэмцэлд чухал, магадгүй *хамгийн* чухал бооцоо болчихсон, болох ч болно. Төрт улсууд өмнө нь газар нутгийг эрхшээлдээ оруулахын төлөө, дараа нь түүхий эд, хямд ажиллах хүчийг захирах, ашиглахын төлөө дайтаж байсан шигээ ирээдүйд мэдээллийг хянахын төлөө тулалдана хэмээн үзэж болох юм. Тэгэхээр нэг талаас аж үйлдвэр,

худалдааны стратегид, нөгөө талаас цэрэг, улстөрийн стратегид шинэ талбар нээгдэж байна^{xxi}.

Гэвч саяын тоймлосон хэтийн төлөв миний илэрхийлсэнчлэн энгийн биш. Учир нь мэдээллийг үйлдвэрлэх, түгээх тал дээр төрт улсуудын дурладаг, дурласаар байгаа онцгой эрхэнд мэдлэгийн худалдаа нөлөөлөх болтой. Мэдлэг нь нийгмийн «уураг тархи» буюу «оюун ухаан» болох Төрийн мэдэлд хамаатай хэмээх үзэл нийгэмд орчигч мэдээнүүд мэдээллээр баян байж, хялбархан тайлагдаж байвал л нийгэм оршин тогтнож, хөгждөг гэсэн сөрөг зарчим хүчирхэгжихийн хэрээр улам бүр үеэ өнгөрөөнө. Мэдлэгийн худалдаатай зэрэгцэн гарч ирж байгаа холбоо харилцааны «тунгалаг байдлын» үзэл суртал Төрийг бүрхэг байдал, «шуугиан»-ы хүчин зүйл мэтээр үзэж эхлэнэ. Энэ үзлийн үүднээс бол эдийн засгийн болон төрийн хүчний хоорондын харилцаа нь тулгамдсан шинэ асуудал үүсгэх аюултай.

Сүүлийн хэдэн арван жилд эдийн засгийн хүчнүүд *үндэстэн дамнасан корпораци* гэдэг ерөнхий нэрээр яваа капитал эргэлтийн шинэ хэлбэрээр төрийн тогтвортой байдалд занал учруулах хэмжээнд хүрсэн. Эргэлтийн эдгээр шинэ хэлбэр хөрөнгө оруулалтын шийдвэр заримдаа төрт улсын хяналтаас гадуур гардагийг ойлгуулдаг^{xxii}. Мэдээллийн технологи, телематик хөгжихийн хэрээр эл асуудал улам л эмзэг болно. IBM шиг фирм дэлхийн тойрог замын нэг бүст харилцаа холбооны хиймэл дагуул эсвэл мэдээллийн банк суулгасан хиймэл дагуул байрлуулах шийдвэр гаргалаа гэж үзье. Түүнд хэн нэвтрэх вэ? Хориотой суваг, мэдээг хэн тогтоох вэ? Төр үү? эсвэл Төр нь хэрэглэгчдийн нэг л байх уу? Иймд эрхзүйн шинэ асуудал, үүнээс улбаалаад “хэн мэдэх вэ?” гэсэн асуулт урган гарна.

Мэдлэгийн мөн чанарын өөрчлөлт нь тэгэхээр оршин буй төрийн хүчнүүдийг том корпорацитай, илүү өргөн утгаараа бол иргэний нийгэмтэй харилцах (de jure болон de facto аль аль) харилцаагаа эргэн харахад хүргэх дам нөлөө үзүүлсэн. Дэлхийн зах зээлийн ахин нээгдэлт, эдийн засгийн ширүүн өрсөлдөөний шинэ эргэлт, Америкийн капитализмын онцгой оройллын уналт, социалист хувилбарын мөхөл, Хятадын зах зээл нээгдэх боломж болон өөр бусад олон хүчин зүйл 1970-аад оны төгсгөлд хэдийнэ бодитой болж, Төрүүд 1930-аад оноос эрхлээд дадчихсан хөрөнгө оруулалтыг чиглүүлэх, тэр бүү хэл удирдахад оролцдог байсан үүргээ нухацтай хянан үзэхээр бэлдээд эхэллээ^{xxiii}. Ийм нөхцөлд шинэ технологиуд тийн хянан үзэхийг улам бүр шавдуулах л болно, учир нь тэд шийдвэр гаргахад хэрэглэгдэх мэдээллийг (иймд хяналтын хэрэгслийг) улам тогтворгүй, дээрэмд өртөмтгий болгодог.

Эрдэм мэдлэг нь «боловсролын» үнэлэмж эсвэл улстөрийн (удирдлага, дипломат, цэргийн) ач холбогдлоороо тархахын оронд мөнгөтэй адилхан замаар эргэлтэнд орно гэж, үүнтэй зохицсон ангилал нь мэдлэг/мэдлэг биш гэсэн хуваалт байхаа больж, харин мөнгөн гүйлгээнд байдаг шиг «төлбөрийн мэдлэг»/ «хөрөнгө оруулалтын мэдлэг» өөрөөр хэлбэл өдөр тутмын амьдралыг тэтгэх (ажиллах хүчний нөхөн үйлдвэрлэл, «амьдрах») хүрээнд борлогддог нэгж мэдлэг, эсрэг хувилбар нь төслийн гүйцэтгэлийг төгөлдөржүүлэх зорилготой мэдлэгийн сан байна хэмээн төсөөлж болно.

Энэ тохиолдолд холбоо харилцааны тунгалаг байдал нь либерализмтай адилтгагдана. Зарим суваг нь шийдвэр гаргахад, зарим нь зөвхөн төлбөр тооцоонд тохирдог мөнгөн урсгалын тогтолцоонд либерализм саад учруулдаггүй. Үүнчлэн нэг хэсэг нь «шийдвэр гаргагчдад», нөгөө хэсэг нь нийгмийн харилцаанд орсон хүн бүрийн мөнхийн төлөөсөнд зориулагдах нэг мөн чанартай ижил сувгуудаар мэдлэгийн урсгал эргэлддэгээр төсөөлж болох юм.

ⁱ Орчуулсан: Ц.Нямсүрэн (ЭМШУИС, НХУТ-ийн багш), Б.Дагзмаа (МУИС, Философийн тэнхимийн багш)

ⁱⁱ Turaine A., *La Société postindustrielle* (Paris: Denoël, 1969); Bell D., *The Coming of Post-Industrial Society* (New York: Basic Books 1973); Hassan I., *The Dismemberment of Orpheus: Toward a Post Modern Literature* (New York: Oxford U.P., 1971); Benamou M. & Caramello Ch. (ed.) *Performance in Post modern Culture* (Wisconsin: Center for XXth Century Studies & Coda Press, 1977); Köhler M. "Postmodernismus: ein begriffsgeschichtlicher Überblick" *Amerikastudien* 22,1 (1977).

ⁱⁱⁱ Уран сайхны дүрслэлийг нь Butor M., *Mobile: Etude pour une représentation des Etats-Unis* (Paris: Gallimard) 1962-д сонгодог байдлаар үзүүлсэн байгаа.

^{iv} Fowles Jib (ed.) *Handbook of Futures Research* (Westport, Conn.: Greenwood Press, 1978).

^v Troubetskoy N.S., *Grundzüge der Phonologie* (Prague: T.C.L.P., VII, 1939).

^{vi} Wiener N., *Cybernetics and Society: The Human Use of Human Beings* (Boston: Houghton Mifflin, 1949); Ashby W.R., *An Introduction to Cybernetics* (London: Chapman and Hall, 1956).

^{vii} Жон фон Нейманы бүтээлүүдийг үз (Johannes von Neumann, 1903-57).

^{viii} Bellert S., "La formalisation des systèmes cybernétiques," *Le concept d'information dans la science contemporaine* (Paris: Minuit, 1965).

^{ix} Mounin G., *Les Problèmes théoriques de la traduction* (Paris Gallimard, 1963). 1965 онд IBM-360-г бүтээсэн нь компьютерийн түүхэнд хувьсгал болсон юм. Moch R., "Le tournant informatique", *Documents contributifs, Annexe 4, L'Informatisation de la société* (Paris: La Documentation française, 1978); Ashby R.M., "La Seconde Génération de la micro-électronique", *La Recherche* 2(1970):127ff.

^x Gaudfernand C.L. & Taïb A., "Glossaire" // *L'Information de la société* /Nora P., Minc A. (Paris: La Documentation française, 1978). Мөн тэнд: Béca R., "Les banques de données," *Nouvelle informatique et nouvelle croissance, Annexe I, L'Information de la société*.

^{xi} Мөн тэнд: Joyeux L., "Les applications avancées de l'informatique" (report of International Resource Development : *The Home Terminal* (Conn.: I.D.R. Press, 1979 эх сурвалжаар бол) Гэр ахуйн цахим хэрэгслийг 1984 оноос эхлэн 1400\$-н анхны үнэтэйгээр АНУ-д худалдаж эхэлжээ.

^{xii} Watzlawick P., Helmick-Beavin J., Jackson D., *Pragmatics of Human Communication: A Study of International Patterns, Pathologies, and Paradoxes* (New York: Norton, 1967).

^{xiii} Эдийн засаг, технологийн системийн анализ, хөгжлийн бүлэг (GAPSET)-н Ж.М. Трель (Treille J.M.) "Бид санах ой ялангуяа хагас дамжуулагч болон лазерийн төхөөрөмж түгэх шинэ боломжийг төдийлөн ярихгүй байна (...) Удахгүй хүн бүр багахан мөнгө төлөөд дурын газраас мэдээлэл цуглуулж болохоос гадна түүнийг өөрсдөө боловсруулах чадалтай болно" хэмээн мэдэгдэж байна ("La Semaine média", #16. 16 février 1979). Шинжлэх ухааны үндэсний хүрээлэнгийн судалгааны үр дүнгээс үзэхэд нэгээс бусад ахлах сургуулийн оюутнууд нэг компьютерийг хоёулаа ашиглаж байна; харин 1980-аад оны эхэн гэхэд сургууль бүр нэг нэгтэй болно. ("La semaine média", #13. 25 janvier 1979)

^{xiv} Brunel L., *Des machines et des hommes* (Montréal: Québec Science, 1978). Missika J.L., Wolton D., *Les réseaux pensants* (Librairie technique et documentaire, 1978). Квэбэк, Франц хоорондын видео бага хурал өнөө хэвийн зүйл болсон: 1978 оны арваннэг, арванхоёрдугаар сард нэг талаас Квэбэк, Монреал, нөгөө талаас Квэбэк, Париж (Paris Nord Их Сургууль, Жорж Помпидугийн Төв) хооронд (“Симфони” хиймэл дагуулыг ашиглан) дөрвөн удаагийн видео бага хурлыг шууд дамжуулсан. (“La semaine media”, #5. 30 novembre 1978). Өөр нэг жишээ бол цахим сэтгүүлзүй. Америкийн томоохон гурван сүлжээ ABC, NBC, CBS нь болж буй үйл явдал бүрийг цахим хэлбэрт буулган, хиймэл дагуулаар Америкийн Нэгдсэн Улсад дамжуулж чадахуйц хэмжээнд үйлдвэрлэлийн студиудаа дэлхийгээр нэг байрлуулжээ. Зөвхөн Москвагийн товчоо л Франкфуртаас хиймэл дагуулд дамжуулахаар тийш хүргэж өгдөг плёнкуудтайгаа ажилласаар байна. Лондон их том зангилаа төв болжээ. (“La semaine media”, #20. 15 mars 1979).

^{xv} Мэдээллийн нэгж нь бит юм. Үүний тодорхойлолтыг Gaudfernan & Taïb, “Glossaire”; мөн Thom R. “Un protée de la sémantique: l’information” (1973)//*Modèles mathématiques de la morphogénèse* (Paris: Union Générale d’Edition, 1974) 10/18, 1974-с үз. Мэдээг тоон кодоор бичих нь тухайлбал хоёрдмол утгаас зайлсхийх боломж олгодог. Watzlawick et al. Op.cit. P.98-с үз.

^{xvi} Тус бүр нь ой санамжаасаа 1500 үг дуудан хэд хэдэн хэл дээр зэрэг ажилладаг дөрвөн модултай халаасны орчуулагчийг зах зээлд нийлүүлж байгаагаа Craig, Lexicon фирмүүд зарлаж байна. Цагт 600-2400 үг орчуулах дундаж орчуулагчийн чадалтай Multilingual Word Processing-г Weider Communication Systems Inc. бүтээжээ. Тэр нь хоёр хэлний толь бичиг, синоним үгийн толь бичиг, дүрмийн тайлбар гэсэн гурван төрлийн ой санамжтай аж (“La semaine media”, #6. 6 décembre 1978.p.5).

^{xvii} Habermas J., *Erkenntnis und Interesse*. (Frankfurt a/M.: Suhrkamp, 1968).

^{xviii} “Нийгмийг бүрдүүлэгч хүний оршихуй дахь байгалийн ноёрхол хийгээд оюун ухаан нь баялаг, үйлдвэрлэлийн үндэс (Grundpfeiler) болсон” учраас Маркс “Grundrisse der Kritik der politischen Ökonomie (1857-1858)”-доо “мэдлэг шууд үйлдвэрлэх хүч болно” хэмээн бичсэн. Ямарч тохиолдолд мэдлэг нь “мэдлэг хэлбэрээрээ биш харин социаль праксисын зэвсэг хувьдаа” өөрөөр хэлбэл “биежсэн мэдлэгийн хүчинд хүний гараар бүтсэн, хүний уураг тархины хэсэг” болсон машины хэлбэрээрээ хүч болно гэдэгтэй Маркс санал нэг байдаг. Mattick P., *Marx and Keynes: The Limits of the Mixed Economy* (Boston: Sargent, 1969) мөн Lyotard J.F. “La place de l’aliénation dans le retournement marxiste” (1969)//*Dérive à partir de Marx et Freud* (Paris: Union Générale d’Edition, 10/18, 1973-с үз).

^{xix} (1950-1971) хорин жилийн дотор АНУ-д ажилчдын бүтэц дараах байдлаар өөрчлөгджээ:

	1950	1971
Үйлдвэр, үйлчилгээ, хөдөө аж ахуйн салбарт ажиллагсад	62.5%	51.4%
Мэргэжилтэн, техникч нар	7.5%	14.2%
Цагаан захтанууд	30%	34%

(Statistical Abstracts, 1971)

^{xx} Байгалийн баялгийг олборлох юмуу мөнгөн-хөрөнгийг эргэлдүүлэх хугацаатай харьцуулбал өндөр зэрэглэлийн техникч юмуу дундаж эрдэмтэнийг “бэлтгэхэд” шаарддаг хугацаанаас болоод. 1960-аад оны эцэст Мэйтик хөгжил буурай орнуудын оюуны талбар дахь цэвэр хөрөнгө оруулалтын хувийг ҮНБ-ий 3-5% , харин хөгжсөн орнуудад 10-15% гэж үнэлжээ.

^{xxi} Nora & Minc, *L’Informatisation de la société*. Op.cit., тухайлаад “Les défis” хэмээх нэгдүгээр хэсгийг, Stourdzé Y., *Les Etats-Unis et la guerre des communications*//Le Monde. 13-15 décembre 1978-г үз. Цахим харилцаа холбооны төхөөрөмжийн дэлхийн зах зээлийн өртөг 1979 онд 30 тэрбум долларт хүрчээ; харин арван жилийн дараа 68 тэрбум долларт хүрнэ гэж тооцож байна. (“La semaine media”, #19. 8 mars 1979.P.9)

^{xxii} De Combret F., *Le redéploiement industriel*//Le Monde. Avril, 1978; Lepage M., *Demain le capitalisme* (Paris, Le Livre de Poche, 1978); Cotta A., *La France et l’impératif mondial* (Paris: PUF, 1978).

^{xxiii} “Засаг захиргааг багасгаж”, “төрийг хамгийн бага”-д хүргэх тухай асуудал юм. Энэ бол 1974 онд эхэлсэн “хямралыг” дагуулсан “халамжлагч” төрийн уналт мөн.